

ТҮҮХЧЛЭХ ҮЗЛИЙН ТАЛААР ЭРГЭЦҮҮЛЭХЭД

Ш.Ганхуяг

МУИС, Нийгмийн шинжлэх ухааны сургууль

Түлхүүр үг: Positivism, Popper, Science Philosophy, Open Society, Historicism, Vienna Circle, Falsifiability, Theory of Knowledge

Товч утга: Поппер "Түүхчлэх үзлийн гуйланчлал" зохиолдоо түүх-нийгмийн тухай өмнөх үеийн философичдын сургаалуудыг шүүмжилсэн юм. Түүхийн хөгжлийн чиг хандлагыг тогтооход түүх-нийгмийн сургаалын зорилго оршино гэж үздэг арга зүйг тэрээр няцаасан байна. Түүхэн хөгжлийг урьдчилан тогтоох боломжгүй гэж тэрээр үзсэн юм. Ер нь нийгмийн шинжлэх ухааны ямар ч мэдлэг мөнхийн хуулийг тогтоож чадахгүй. Учир нь нийгэм өөрөө байнгын хөдөлгөөнд орших тул түүнд хөгжлийн мөнхийн хууль гэж байхгүй гэж Поппер үзжээ.

Орчин үеийн түүхийн философийн аргазүйн асуудал дээр өмнөх үеийн философичдыг "түүхчлэх үзлээр" нь шүүмжилсэн "Нээлттэй нийгмийн" тухай Австрийн философич, социологич К.Попперийн философийн аргазүйг тойрсон янз бүрийн маргаан хэлэлцүүлэг өргөн явагддаг.

"Нээлттэй нийгмийн" тухай үзлийг анх Г.Бергсон дэвшүүлэн тавьжээ. Тэрээр хаалттай нийгэм нь хаалттай үзэл санаа, хаалттай шашин, хаалттай хууль эрхийн системтэй адил статик, зогсонги шинжтэй бөгөөд харин нээлттэй нийгэм нь динамик, хөдлөнги шинж чанараараа ялгарна гэж үзжээ. Хаалттай нийгмийн гишүүд нь анги бүлгийн үзэл санаанд баригдсан байдаг. Харин нээлттэй нийгмийн гишүүд нь түгээмэл, универсаль ёс суртахуунтай байна гэж тэрээр тайлбарласан юм. Энэ үзлийг К.Р.Поппер 1945 онд бичсэн "Нээлттэй нийгэм ба түүний дайснууд" зохиолдоо хөгжүүлэн боловсруулжээ.

Попперийн гол үйл ажиллагаа нь мэдлэгийн тухай онолыг боловсруулах явдал байсан бөгөөд мэдлэгийг шинжлэх ухааны мэдлэг гэдэг талаас нь судалбал илүү зохистой гэж тэрээр үзсэн байна. Гэхдээ шинжлэх ухааны мэдлэг нь няцаалтад өртөх боломжтой байвал сая жинхэнэ шинжлэх ухааны

мэдлэг мөн гэж тооцож болно хэмээн дүгнэсэн юм. Няцаалт л шинжлэх ухааныг цааш хөгжүүлэх үндэс болдог гэж Поппер үзсэн юм.

Энэ үзэл нь түүх нийгмийн асуудлыг тайлбарлахад нөлөөлжээ. "Түүхэн тодорхой үед амьдарч буй хүмүүсийн олонхи нь орчноосоо ажиглаж буй тогтонги чанарыг бүх нийгэмд адил хүчин төгөлдөр нийгмийн амьдралын даяар түгээмэл хууль мөн гэх ташаа үзэлд автагдана гэсэн бодлоос би шүүмжлэлээ эхлээ. үнэхээр ч бид дуртай үзлийнхээ алдаатайг хааяа, тухайлбал, бидний хооллох зуршил, мэндлэх журам гэх мэт нь бидний гэнэн цайлган бодсончлон бусдын нутагт огтхон ч дэлгэрээгүйг хараад ойлгодог болой"¹. Попперийн үзлээр нийгмийн зохион байгуулалт нь няцаагдан шүүгдэх боломжгүй бол хаалттай нийгэм болж зогсонги байдалд орно, харин няцаалт шүүмжлэлд байнга өртөж өөрөө өөрийгөө цэвэрлэж чадаж байгаа нийгэм нь нээлттэй нийгэм болж хөгжин дэвжих бололцоог олно гэж тайлбарласан юм.

Поппер "Түүхчлэх үзлийн гуйланчлал" зохиолдоо түүх-нийгмийн тухай өмнөх үеийн философичдын сургаалуудыг шүүмжилсэн байдаг. "Түүхчлэхүйн гол номлолын ёсоор бол түүх өөрөө түүхийн буюу хувьслын өвөрмөц хуулиудад захирагддаг, тэдгээрийг нээснээр бид хүний хувь тавиланг төлгөлөн хэлж чадах ёстой хэмээнэ"² хэмээн Поппер түүхэн хөгжлийн хууль зүй тогтлыг тогтоох замаар түүхэн ирээдүйг тогтоох гэсэн аливаа оролдлогыг шүүмжилсэн байна. Үнэндээ философийн түүхэнд түүх-нийгмийн асуудлыг судалсан философичдын дийлэнх нь ерөнхий түгээмэл хууль зүй тогтлыг тогтоох замаар хүн төрөлхтөний ирээдүйг заах оролдлого хийсэн байдаг. Гэхдээ энэ оролдлого нь өөрөө түүх-нийгмийн талаархи хүн төрөлхтөний мэдлэгийг хөгжүүлэх үндэс болж, Попперийн үзэл бүрэлдэхэд ч нөлөөлсөн байдгийг бид философийн түүхийн судалгаанаас харж болно.

Макиавелли (1469-1527) нийгэмд хичнээн ч өөрчлөлт болсон, нэг засаглал нөгөөгөөр солигдлоо ч байнгын хувиршгүй хууль зүй тогтол гэж байна.

Тэрхүү хууль зүй тогтлыг судалж мэдэх нь шинжлэх ухааны зорилго мөн гэсэн байдаг бол Монтескье (1689-1755) түүхийн философийн гол зорилгыг нийгэм-түүхийн хөгжлийн хууль зүй тогтлыг илрүүлэн, төр нийгмийн

¹ К.Поппер. Түүхчлэх үзлийн гуйланчлал. Улаанбаатар 1996. х117

² К.Поппер. Нээлттэй нийгэм ба түүний дайснууд. Улаанбаатар 2006. х.16

байгууллауд олон янз байдгийн учрыг тайлбарлаж, нийгмийн амьдралын олон талт хүрээний дотоод нэгдмэл уялдаа холбоог тогтоох явдал гэж тайлбарлажээ. Философийн түүхэнд бий болж хөгжин боловсорсон энэ мэт үзлийн уриан дор философичид хүн нийгмийн хөгжлийн учир шалтгааныг бурхан тэнгэр, гадны хүчнээс бус өөрөөс нь эрэн сурвалжилж, өөрийнх нь хүчин чадлыг тогтоох оролдлого хийж ирсэн нь хүний хүчин зүйлийг дээдлэх үзлийн хөгжилд хувь нэмрээ оруулсныг үгүйсгэж болохгүй.

Гэхдээ Попперийн философид түүхийн хөгжлийн учир холбогдлыг тэнгэр бурханы хүчээр тайлбарлах ба газар дэлхийн хуулиар тайлбарлахын хооронд ялгаа байхгүй гэсэнд хэргийн учир оршиж байгаа юм. Поппер бичихдээ: "Миний өдий хүртэл зөвхөн нэлээд хийсвэрлэх байдлаар тодорхойлж ирсэн түүхчлэхүйг түүний хамгийн эртний, хамгийн эгэл хэлбэрийн нэг болох шилэгдмэл ард түмний тухай номлол дээр тодорхой харуулж болно. Энэ номлол бол түүхийг шүтэхүйн үүднээс ойлгон ухаарах гэсэн нэгэн оролдлого... Энэ номлолын дагуу бол түүхэн хөгжлийн хуулийг Бурхан өөрийн тааллаар тогтоожээ. Түүхчлэхүйн бусад хэлбэрээс шүтэхүйн хэлбэрийнх нь ялгарах онцлог чухамдаа энэ юм. Жишээлбэл, байгалийн түүхчлэхүй хөгжлийн хуулийг байгалийн хууль мэтээр тайлбарлана; оюуны түүхчлэхүй түүнийг оюуны хөгжлийн хууль гэж тайлбарлана; эдийн засгийн түүхчлэхүй, бас л эдийн засгийн хууль гэнэ. Шүтэхүйн түүхчлэхүй нь эдгээр бусад хэлбэрийн нэгэн адил түүхийн өвөрмөц хуулиуд бий, тэдгээрийг нээн илрүүлж болно, хүн төрөлхтний тухай таамаглалыг тэдгээрт үндэслэн гаргаж болно гэж үздэг"¹.

Контын урьдчилан харж чадаж байгаа газарт шинжлэх ухаан байна, харин үйл хэрэг байгаа газарт урьдчилан харж чадна гэсэн энгийн хуулиар шинжлэх ухаан хөгжинө гэжээ. Конт физикт байгалийн үзэгдлийн хуулийг яаж тогтоодог вэ, социологи нь яг тийм байдлаар ажиглалт, бясалгалд тулгуурлан нийгмийн үзэгдлийн хууль зарчмыг тогтооно хэмээжээ. Ийм үзэл баримтлагчдыг Поппер шүүмжилж: "тэд хандлагыг хуулийн адил нөхцөлдөөгүй гэж ханддаг. Хууль болон хандлагыг хутгасан нь болзмол бус хандлагад, эсвэл, үнэмлэхүй хандлагад, жишээлбэл, дэвшилд чиглэсэн нийт түүхэн

¹ К.Поппер. Нээлттэй нийгэм ба түүний дайснууд. Улаанбаатар 2006, х.17

хандлагад, илүү сайн, илүү жаргалтай байдалд чиглэсэн хандлагад итгэхийг тулгаж байна... Энэ бол түүхчлэх үзлийн гол алдаа"¹ гэжээ.

Конт шинжлэх ухаан л хүмүүсийг байгалийн эзэн болгоно гэж үзсэнээрээ Бэкон, Декарт нартай санал нэгдсэн боловч шинжлэх ухааныг техник-практик мэдлэгээс ялгаатай гээд, жинхэнэ шинжлэх ухаан нь баримт материалыг биш, хууль зарчмыг гол болгоно гэснээрээ социологийн зорилгыг өөрийнхөөрөө тодорхойлсон юм. Харин Бэконы төөрөгдлүүдийн талаар авч үзээд К.Поппер: хүний ухаан гэдэг бол хэзээ ч цэвэр самбар байдаггүй, янз бүрийн үзэл суртлаар дүүрэн байдаг бөгөөд амьдрал туршлагаараа өөрөөсөө зайлуулах зүйлсийг ухаарч байдаг, цэвэр оюун ухаан юу ч харж чадахгүй гэсэн байдаг.

Контын дээрхи үзлийг хөгжүүлж Вебер шинжлэх ухаан нь ямагт шалган тогтоох хууль дүрэм, баталгааг үндэслэх ёстой гэж сургаж байв. Түүхийн болон социологийн шинжлэх ухааны хэлийг илүү тодорхой болгохын тулд олон янз үзэгдлүүдийг холбох "дээд загварын" тухай онолыг боловсруулах хэрэгтэй. Энэ нь нийгмийн олон үзэгдлүүдийг нэгэн хэмжүүрт оруулах арга зүйн ач холбогдолтой бөгөөд тэрхүү дээд загварт хэр ойр байгаагаар нь шалгуур болгоно гэсэн үг хэмээн Вебер үзсэн байдаг. Түүхэн үзэгдлийг тайлбарлахад хууль зарчмын талаархи мэдлэг хэрэгтэй болно. Түүнийг түүхчид социологоос авна. Социолог нь түүхэн үзэгдлүүдийн холбоо харилцаа, хүмүүсийн үйл ажиллагааны зохицуулалтыг илрүүлэн гаргана. Нэгэн үзэгдлийн учир шалтгааныг тогтоосноор бусад шалтгаан үзэгдлүүдийг хөөн судлах боломж олдох ба ийнхүү тал бүрийн шинжилгээ нь бодит үнэнийг тогтооход туслана гэх мэтээр Вебер түүхийн философийн судалгааны аргыг тайлбарлажээ.

Конт, Вебер нарын иймэрхүү үзлийг Поппер Платоны үзлээр жишээ авч шүүмжилжээ: "Платон анхны нийгмийн философичдын нэг байсан бөгөөд эдүгээ ч түүний нөлөө асар их гэдэг нь ямар ч эргэлзээгүй юм. Тэр бол "социологи" гэдэг нэр томъёог Конт, Милль, Спенсер нарын ойлгож байсан яг тэр утгат дүйх социологич байжээ. Өөрөөр хэлбэл Платон хүний нийгмийн амьдрал болон түүний хөгжлийн хууль, түүнчлэн тэрхүү нийгмийн амьдралын тогтвортой байдлын нөхцөл болон хуулиудад өөрийнхөө идеалист аргыг

¹ К.Поппер. Түүхчлэх үзлийн гуйланчлал. Улаанбаатар 1996. х146-147

амжилттай хэрэглэсэн юм... Тэрээр энэ идеалист суурин дээр нийгмийн тухай гайхалтай бодит онолыг бүтээжээ. Энэхүү онол нь Грекийн хот-улсын түүхэн хөгжлийн үндсэн хандлагыг төдийгүй тухайн үед үйлчилж байсан нийгэм, улс төрийн хүчний шинж төрхийг тайлбарлаж чадсан юм"¹ гэж тэрээр бичсэн байдаг.

Түүхийн хөгжлийн чиг хандлагыг тогтооход түүх-нийгмийн сургаалын зорилго оршино гэж үздэг арга зүйг Поппер няцаасан байна. Түүхэн хөгжлийг урьдчилан тогтоох боломжгүй гэж тэрээр үзсэн юм. Ер нь нийгмийн шинжлэх ухааны ямар ч мэдлэг мөнхийн хуулийг тогтоож чадахгүй. Учир нь нийгэм өөрөө байнгын хөдөлгөөнд орших тул түүнд хөгжлийн мөнхийн хууль гэж байхгүй гэж тэрээр үзжээ. Поппер шинжлэх ухааны философийн аргазүйн зарчмаар марксист түүхэн материализмыг шүүмжилж, нийгмийн хөгжлийн объектив хууль зүй тогтлыг няцаасан байна. Тэгээд ч ямар нэгэн сургаалыг баримталж түүх хөгжинө гэвэл түүн шиг хуурамч үзэгдэл байхгүй, иймээс Платоны төрийн тухай сургаал ч, марксист түүхэн материалист сургаал ч нийгмийн хөгжлийн удирдамж болж чадахгүй юм. Хүн, нийгмийн аливаа үйл ажиллагаа нь урьдчилан тогтоож заасан чиг хандлагаар явагдахгүй, харин бодит байдлыг шүүмжлэн няцааж хувирган өөрчлөх үйл явц л түүхийг урагш хөгжүүлдэг гэж үзжээ. "Даяар түгээмэл хуулиуд бол тодорхой төрлийн бүх үйл явцад холбогдох баталгаа юм, хэдийгээр нэгж ажиглалт нь биднийг даяар түгээмэл хууль томъёолоход хүргэж, тэр ч байтугай үнэнтэй биднийг нүүр тулгаж болохыг үгүйсгэх шалтгаан үгүй боловч аль ч хууль ямраар ч томъёологдсон байлаа гэхэд шинжлэх ухаанд жинхэнэ ёсоор орохын тулд давтан шалгагдсан байх ёстой"².

Поппер нь Фрейд, Адлер нарын психологийн онолыг болон Платоны, мөн Марксист сургаалыг няцаалтад өртддөггүй, шүүмжилж болохооргүй байдлаар асуудлыг боловсруулсан гэдэг үндэслэлээр шинжлэх ухааны мэдлэг биш хэмээн шүүмжилсэн юм. Фальсификацид орж няцаагдах боломжтой байдал нь шинжлэх ухааны онолын гол шинж чанар мөн.

¹ К.Поппер. Нээлттэй нийгэм ба түүний дайснууд. Улаанбаатар 2006. х.43

² К.Поппер. Түүхчлэх үзлийн гуйланчлал. Улаанбаатар 1996. х.126

Социалист гэгдэж байсан орнуудад цорын ганц үнэн сургаал хэмээн дээдлэгдсэн Марксын сургаал бурханы сургаал болж чадаагүй юм. Хөдөлмөрчин ард түмнийг үй олноор нь үгээгүйрүүлсэн капиталист гүрнүүдийн дотор пролетарийн хувьсгал зүй тогтлоороо гарах ёстой байсан боловч тэдгээр орнууд социалист орнуудаас илүү хурдацтай хөгжсөөр байв. Өндөр хөгжилтэй капиталист орнууд дахь аж үйлдвэр, техник, зах зээлийн эдийн засгийн хөгжил нь зөрчлийг улам бүр хурдасгах ёстой байлаа. Энэ тохиолдолд марксист сургаалд шүүмжлэлтэй хандахын оронд түүнийг тал талаас нь засварлаж эхэлсэн юм. Ингэснээр Марксын сургаалыг марксистуудаас хамгаалахад хүргэсэн хэмээн Поппер шүүмжилжээ. "Нийгмийн туршилт хийх бололцоотой бол, бүрэнч цар хүрээгээр хэрэгжиж байгаа бол үнэ цэнэтэй болох юм гэдэг дээр утопи ба түүхчлэх үзэлтнүүд санал нийлж байгаа... Энэ үлэмж дэлгэрсэн үзэл нь нийгмийн салбарт төлөвлөгөөт туршилт хэрэгжүүлэхэд бид тэр бүр бэлэн байдаггүй, мөн эдүгээ хүртэл эл салбарт хийж байсан санамсаргүй туршилтуудын үр дүнгийн талаар бид түүхэнд хандах ёстой гэсэн"¹.

Түүхэн хөгжлийн хууль зүй тогтлыг тогтоосон сонгодог философийн онол бол Марксын боловсруулсан формацийн онол мөн билээ. Маркс хөрөнгөтөн нийгмийн хөгжлийн өвөрмөц хуулийг судалсны үндсэн дээр ерөнхий түгээмэл хууль зүй тогтлын тухай шинжлэх ухааны ойлголтыг хөгжүүлсэн билээ. Нийгэмд үйлдвэрлэлийн харилцаа нь үйлдвэрлэх хүчний түвшин ба шинж чанарт тохирох хууль үйлчилдэг гээд үйлдвэрлэлийн харилцаа нь үйлдвэрлэх хүчин, түүний хөгжлийн түвшнээс хамаарна гэсэн үзлийг Маркс номлосон юм. Үйлдвэрлэл нь тасралтгүй дэвшин хөгждөг учраас үйлдвэрлэх хүчний хөгжил нь өмнөх нийгэмд бүрэлдсэн үйлдвэрлэлийн харилцаатай зайлшгүй зөрчилд хүрдэг. Ангийн зөрчилт нийгэмд ноёрхогч анги нь өөрийн улс төрийн ноёрхлын эдийн засгийн үндэс болсон үйлдвэрлэлийн хуучин харилцаагаа хадгалахыг хүсдэг учраас зөрчил нь тэмцэлд хүрдэг. Энэ нь шинэ үйлдвэрлэх хүчинд тохирсон үйлдвэрлэлийн шинэ харилцааг тогтоох хувьсгалд хүргэнэ гэж Маркс үзсэн байна.

¹ К.Поппер. Түүхчлэх үзлийн гуйланчлал. Улаанбаатар 1996. х102

"Үл гүйцэлдэх үзэлд... байдаг нэг өвөрмөц шинжтэй элемент бий. Энэ нь хэдийгээр бодитой бус гэж миний шүүмжилж байгаа элементүүдээс хамгийн чухал нь байж магадгүй боловч Маркс түүнийг эсэргүүцээгүй байгаа юм. Энэ бол Үл гүйцэлдэх үзлийн энгүй далайц, нийгмийг бүхэлд нь орвонгоор нь өөрчлөх гэсэн оролдлого... Платон, Маркс хоёр нийгмийн ертөнцийг бүхэлд нь өөрчлөх "галав юүлэх" хувьсгалын тухай мөрөөдөцгөөж байжээ"¹. Шүүмжлэлд өртөх чадвартай шинжлэх ухааны судалгаанд тулгуурласан нээлттэй нийгэм нь ардчилсан нийгэм байна гэж Поппер үзээд иргэд нь дайн тулаанд хүрэхгүйгээр засаглалаа хянаж шүүмжлэх замаар төрийг удирдах боломжийг бүрдүүлж чадах нийгмийн байгууллагуудыг хадгалж байвал тэр нь ардчилал мөн гэжээ. "Би хэзээ ч хүч хэрэглэсэн хувьсгалын эсрэг байна" гэж Поппер бичсэн байдаг.

Попперийн үзлээр ардчилал гэдэг бол олонхийн засаглал биш, харин цөөнхийг сонсч чаддаг засаглал мөн. Ардчилсан хууль нь зөвхөн ардчилалд өөрт нь аюул учруулж болох хуулиас л татгалзаж болно. Ардчилал нь хуулийг уландаа гишгэгчид болон олон түмнийг хүч хэрэглэх үйлд татан оруулагчдад нүүр өгдөггүй. Ардчиллыг хамгаалагч улс төрийн хүчин нь ардчиллын эсрэг хандлага төрийн удирдлагад ч, олон нийтийн дотор ч байж болохыг үргэлж санаж байх ёстой. Хууль эрх үйлчилдэггүй газар ардчилал байдаггүй. Хүч хэрэглээгүй л бол ямар ч өөрчлөлтийг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй гэх мэтээр Поппер ардчилал гэдгийг тайлбарласан байдаг.

Поппер түүхэн хөгжлийг урьдчилан тогтоох боломжгүй гэж үзсэн юм. Ер нь нийгмийн шинжлэх ухааны ямар ч мэдлэг мөнхийн хуулийг тогтоож чадахгүй. Учир нь нийгэм өөрөө байнгын хөдөлгөөнд орших тул түүнд чадахгүй. Учир нь нийгэм өөрөө байнгын хөдөлгөөнд орших тул түүнд чадахгүй. Учир нь нийгэм өөрөө байнгын хөдөлгөөнд орших тул түүнд чадахгүй. Учир нь нийгэм өөрөө байнгын хөдөлгөөнд орших тул түүнд чадахгүй.

Марксист үзэл санааны онолын үндэс болох Гегелийн философид нийгмийн хөгжлийн тодорхой үе шат бүхэн нь давтагдашгүй өвөрмөц онцгой байхын зэрэгцээ хүн төрөлхтөний хөгжлийн зайлшгүй хууль зүй тогтолт үйл

¹ К.Поппер. Нээлттэй нийгэм ба түүний дайснууд. Улаанбаатар 2006. х.166

явц болж байдаг гээд дэлхийн түүхийг хөгжиж буй процесс гэж үзсэн юм. Гегелийн үзлээр түүх дээш дээшээ хөгжсөөр хүрэх ёстой дээд цэг нь "туйлын оюун санаа" юм. Ийнхүү нийгэм нь бүхэлдээ түгээмэл оюун ухаан, үнэмлэхүй ухаалаг хуулийн тасралтгүй хөгжил гэж Гегель үзсэн байна.

Гегель оюун ухаан ба бодит байдлыг адилтгаснаараа эртний хүй нэгдлийн байгууллыг Германы төрийн байгуулалтай адилтгасан хэрэг болно гэдгийг Поппер дурьдсан байдаг. Түүхийг хүмүүс өнгөрсөн үеийнхнээсээ хүлээн авдаг гэсэн Марксын үг үнэн боловч түүний диалектик үзэл нь орчин үеийн марксистууд, тоталитаристуудын онолын үндэс болсон бөгөөд Гегель, Маркс нарын диалектик нь шудрага бус байдлын үзэл санаагаар дүүрсэн байдаг гэх мэтээр Поппер шүүмжилжээ. "Түүхчлэх үзэл ба утопи үзлийн холбооны хамгийн хүчтэй элемент бол тэр хоёрт хоёуланд нь нийтлэг бүрэнч тогтоомж мөн гэдэг нь эргэлзээгүй. Түүхчлэх үзэл нийгмийн амьдралын аль нэг талын бус, харин бүхэл нийгмийн хөгжлийг анхааран үздэг, үл гүйцэлдэх бүтээгүй үзэл ч мөн бүрэнч чиглэлтэй... Энэ хоёр тал хэсгийн жижиг завсар ба алдаж онож явсан ч үйл хэргийг эцэст нь тулгахыг чамлаж илүү эрс арга номлодог юм"¹.

Шудрага ёсны тухай асуудал болон хөдөлбөргүй хууль зүй тогтлыг шүүмжилсэн өнгө аяс философийн түүхэнд бүр эрт үеэс ажиглагдсаар ирсэн байдаг. "Орчин үеийн түүхчлэх үзэлтнүүд сургаалаа эртнийх гэдгийг ухаарахгүй байх шиг байна. Тэд түүхчлэх үзлийн өөрсдийн хувилбарыг хүний сэтгэлгээний хамгийн сүүлийн, хамгийн эршүүд ололт, чухам л хирдхийм шинэ, цөөн хүн ухаарч чадах ололт гэж итгэж байна... тэд өмнөх үеийн бүх хүмүүсийн "тэнцэллэг" сэтгэхүйд өөрсдийн "хөдлөхүйн" сэтгэхүйг сөргүүлэн тавихдаа эдүгээ нийгмийн өөрчлөлтийг хүний нэгэн амьдралын хугацаанд шууд туулж болохуйц болтол бидний хөгжлийг хурдасгаж буй "хувьсгалыг амсаж байгаа" баримтын ачаар л өөрсдийн амжилтыг боломжтой болсон гэдэгт итгэж байгаа юм. Энэ бүхэн цөм ёстой домогзүй мөн"², "Манай эриний өмнөх 500-гаад жилийн тэртээгээс үлдсэн бичиг цаасан дотор орчин үеийн

¹ К. Поппер. Түүхчлэх үзлийн гуйланчлал. Улаанбаатар 1996. х.90-91

² К. Поппер. Түүхчлэх үзлийн гуйланчлал. Улаанбаатар 1996. х.180-181

түүхчлэхүй болон ардчиллын эсрэг үзлийн өч төчнөөн шинж илэрч байгаа нь нэн гайхалтай"¹ гэж Поппер бичсэн байдаг.

Роберт Ардиго социологи бол шудрага ёсны үзэл санааг жинхэнээр нь тогтоох онол сургаал мөн гэсэн байдаг. Шудрага ёс нь байгалийн хууль мөн боловч байгалийн хуулиар тогтоосон шудрага ёсны эсрэг нийгмийн шудрага ёсыг позитив хууль эрхээр тогтооно гэж Ардиго үзжээ. Тэрээр нийгмийн хөгжилд эдийн засгийн хууль гол үүрэгтэй гэсэн марксист сургаалыг шүүмжилж эдийн засгийн хуулинд тэр бүр хамаарахгүй олон үзэгдэл нийгмийн амьдралд болдогийг позитив түүхийн философи анхаарлынхаа гадна үлдээж болохгүйг сануулсан байдаг.

Поппер ардчилсан нийгэмд эхлээд эрх чөлөөг тогтоож, дараа нь шудрага ёс бий болно гээд, эрх чөлөө тогтооно гэдэг нь шүүмжлэх боломж өгнө гэсэн үг, шүүмжлэл байхгүй газар шудрага ёсны тухай ярихын ч хэрэггүй гэжээ. Хүн, нийгмийн аливаа үйл ажиллагаа нь урьдчилан тогтоож заасан чиг хандлагаар явагдахгүй, харин бодит байдлыг шүүмжлэн няцааж хувирган өөрчлөх үйл явц л түүхийг урагш хөгжүүлдэг гэж Поппер үзжээ.

Ер нь хууль зүй тогтолд өртдөггүй нийгэм-түүхийн үйл явдлуудын талаар олон философичид дурдаж үзэл бодлоо илэрхийлсэн байдаг. Ницшегийн үзлээр, нийгмийн амьдрал нь хүнд хүчир зовлон, зөрчил тэмцлээр дүүрэн байна гээд рациональ ухаанд суурилсан хууль зарчим гэхээсээ эмх замбараагүй, ухамсаргүй, элий балай иррациональ байдал түүхэнд ноёрхдог гэж үзсэн юм. Тэрээр "Орчин үеийн биш бодролууд" зохиолдоо түүх "хорлогдсон" гэж тодорхойлсон байдаг. Ингэснээрээ Ницше түүхийг няцаасан бус, харин түүхчлэх үзлийн буюу баримт фактыг хэт дээдлэх үзлийн төөрөгдлийг няцаасан юм.

Хууль эрхийн үнэ цэнийг няцааж байгаа анархист (улс төрийн үзэл баримтлалаас ангид) судлаач хүн мэргэжлийн хуульчийн мэдээжийн зүйлийг эргэлзэхэд хүргэж байвал тэр сайн судлаач гэсэн үг хэмээн Вебер ч тайлбарласан байдаг. Вебер хэлэхдээ: Үйл явдлын талаархи өөрийн дүгнэлт,

¹ К. Поппер. Нээлттэй нийгэм ба түүний дайснууд. Улаанбаатар 2006. х. 25

номлол айлдлаа хэлж байгаа багш хүн дуугүй чагнах оюутнуудын өмнөх индрийг өөрийн улс төрийн ашиг сонирхолдоо хэрэглэж байгаа бол тэр судлаач багш биш. Суртал ухуулгыг хичээлийн индэр дээр биш, нийтийн цуглаан дээр хэлэх ёстой. Хэрвээ хичээлийн индэр дээрээс өөрийн үзэл бодлоо хэлэхийг хүсвэл тэр нь өөрийнх нь субъектив үнэлгээ гэдгийг тайлбарлах хэрэгтэй. Багш хүн ямагт судлаач, эрдэмтэн байж оюутнуудыг судлаач болгох гол зорилго тавих ба өөрийн үзэл баримтлалаа шүүн хэлэлцэх боломж тэдэнд олгох хэрэгтэй гэжээ.

Харин Шпенглерийн үзлээр, түүх гэдэг бол хөдөлгөөн, бүрэлдэл, амьдрал мөн бөгөөд амьдралд систем, программ, оюун ухаан гэж байхгүй, тэр нь өөрөө өөртөө л оршдог эх нь ч, адаг нь ч мөн. Түүнийг мэдэрч, бясалгаж, тайлбарлаж л болно. Оюун бодомжиндоо үхмэл хууль зүй тогтол, ойлголт ухагдахууныг оруулбал байгаль бий болно, харин дотоод мэдрэмж, зөн билигтээ хандвал бидний өмнө түүх сүндэрлэнэ гэх мэтээр Шпенглер тайлбарласан байна.

Гэвч иймэрхүү иррациональ хандлагыг ч Поппер түүхчлэх үзлийн тоонд оруулан шүүмжилсэн байдаг. "Түүхчлэгчид нийгмийн элдэв институцийг голдуу түүхийнх нь талаас, өөрөөр хэлбэл, тэдгээрийн үүсэл, хөгжил, түүнчлэн тэдгээрийн өнөөгийн болон ирээдүйн ач холбогдлынх нь талаас авч үзэх хандлагатай байдаг. Тэд нар нийгмийн институцийг тодорхой төлөвлөгөө буюу төслийн дагуу эсвэл хүний юм уу тэнгэрийн тодорхой зорилгыг хэрэгжүүлэх гэсэн эрмэлзлээс үүсэн буй болсон гэж л бараг зүтгэнэ. Тэд, аягүй бол, сайхь байгууллагуудыг ив илэрхий зорилгыг хэрэгжүүлэх үүднээс байгуулсан бус, ердөө л ямар нэгэн зөн, хүсэл зоргын шууд илэрхийлэл гэж нотлож байж ч мэднэ"¹.

Попперийн хамгийн их хэлдэг үг, баримталдаг зарчим нь "шинжлэх ухааныг хүн бүтээдэг учраас алдаа гаргах чадвартай байх ёстой" гэдэг. Шинжлэх ухааны мэдлэг батлагдсан байх ёстой гэсэн (верификацийн) баримтлалыг няцааж, харин ч шинжлэх ухааны үнэн нь байнга няцаагдаж байж шинжлэх ухааны биш мэдлэгээс демаркац шинжээрээ ялгарч байдаг гэсэн

¹ К.Поппер. Нээлттэй нийгэм ба түүний дайснууд. Улаанбаатар 2006. х.33

(фальсификацийн) зарчмыг дэвшүүлсэн билээ. Ингэснээрээ түүхийн философи дахь уламжлалт индуктив аргын оронд дедуктив аргыг хэрэглэсэн юм. Шинжлэх ухааны батлан нотолсон үг өгүүлбэрүүд нь үнэмлэхүй үнэн байж чадахгүй, харин хяналт шалгалтанд байнга өртөх магадлалтай үнэнийг тодорхойлж байвал илүү үр өгөөжтэй болно гэж үзсэн.

Нэгж тусгаар баримтуудыг нэгтгэн дүгнэх индукцийн аргаар шинжлэх ухааны үнэнийг гарган авснаар ерөнхийлөн дүгнэсэн онолууд хязгааргүй үргэлжлэн төрсөөр байх учраас индукцийн арга нь үнэндээ юуг ч үндэслэж чадахгүй гэж Поппер үзжээ. Индукц нь тавтолог буюу аналитик баталгаа, эсвэл эмпирик буюу синтетик баталгаанд үндэслэнэ. Гэвч индуктив гаргалгаагаа бид мөн л илүү өргөн хүрээний индуктив гаргалгаагаар үндэслэх хэрэгтэй болно гэх мэтээр хязгааргүй үргэлжлэнэ. Шинжлэх ухааны ажиглалт туршилт ч мөн адил ямар нэг урьдчилсан таамаглал, онолд тулгуурлан явагдахаас, ямар ч онолгүй цэвэр самбар дээр туршилт явуулахгүй нь ойлгомжтой. Ийнхүү туршлагад үндэслэсэн индуктив аргыг Поппер бүх талаас нь няцаасан юм.

Попперийн үзлээр, аливаа судалгаа нь ажиглалт туршлагаас биш, харин практикийн буюу онолын асуудлаас эхэлдэг. Асуудал нь ямагт эхлээд биологийн эволюцийн байснаа дараа нь түүх-соёлын болж хувирсан асуудал байна. Эндээс сэтгэл зүйн үзэгдэл ба шинжлэх ухааны баталгааны хооронд ялгаа гарч ирнэ. Сэтгэлзүйн үйл ажиллагаа нь гипотезийг томъёолоход хүргэдэг боловч дараа нь энэхүү гипотез баримтаар баталгааждаг гэж Поппер тайлбарласан байдаг. Түүхч хүн үнэлэмжит үг томъёог санамсаргүй байдлаар биш, харин ухамсартайгаар хэрэглэнэ. Аливаа онол батлагдахын тулд бүх талаараа шалгагдах ёстой. Өөрөөр хэлбэл, баримтуудыг фальсификацлах ёстой. Харин шалгагдахгүй байгаа онол нь шинжлэх ухааны онол байж чадахгүй гэж Поппер нотолжээ.

Попперийн үзлээр, түүхийн мэдлэгийн эмпирик ба онолын тал нь өөр хоорондоо салшгүй холбоотой бөгөөд аливаа түүх-нийгмийн мэдлэг нь урьдчилан таамагласан шинжтэй байдаг учраас заавал алдаанд орно гэж үзжээ. Нийгмийн тогтсон үзэл баримтлалыг зоригтой шүүмжлэн няцаах нь

(фальсификацийн арга) асуудлыг шинжлэх ухаанчаар шийдвэрлэх гол арга мөн хэмээн Поппер тодорхойлсон байдаг. Ийм замаар хөгжих түүх-нийгмийн тухай мэдлэгийн өсөлт нь бүх ертөнцийн эволюцийн үйл явц дахь нэгээхэн хэсэг болно гэжээ.

Түүхчлэх үзэл бол хаалттай нийгмийг хамгаалагч тоталитар үзэл суртал мөн гэж Поппер тодорхойлсон байдаг. Ингэхдээ хөдөлбөргүй туйлчлан тогтоосон хэм хэмжээг зохицуулдаг тоталитар зарчмаар зохион байгуулагдсан нийгмийг "хаалттай нийгэм" хэмээн нэрлэсэн байна. Харин "нээлтэй нийгэм" нь хүн төрөлхтний оюун ухааны шүүмжлэгч хүчин чадварт тулгуурлан чөлөөт сэтгэлгээг бүх талаар урамшуулан дэмждэг бөгөөд нийгмийг тасралтгүй шинэчлэн өөрчилж байдаг гэжээ. Энэ утгаар нээлттэй нийгмийн гол үүрэг нь шинжлэх ухааныг тасралтгүй хөгжүүлэх явдал юм.

Summary

Austrian philosopher Karl Poppers works "The Poverty of Historicism" and "The Open society and Its Enemies" are critique of various widely accepted approaches to the methodology of the Philosophy of History. Popper emphasized the conditional character of scientific prediction – its dependence upon universal laws and initial conditions. Popper considers that Falsifiability is a criterion of the scientific character of a theory. Popper was not concerned with meaning, and stressed that metaphysical statements which are not testable – may none the less meaningful and that some had played an important role in the development of science. Popper offered a detailed critique of Plato's, Hegel's, Marks's, Kont's and Miller's works, and he proposed that we should adopt a strategy of piecemeal social planning, in which attempts to solve our collective problems are followed up by the critical scrutiny of their actual outcomes.